МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 29 өдөр Дугаар А/424 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.8-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1,Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус XIII хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн "Залуу багш-шинэ манлайлал" сургалт зөвлөгөөн зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын үйл ажиллагааны болон мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал"-аас гаргаж, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дэмжлэгээр олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зарцуулж тайлагнахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

671 011 031